



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/667

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ховд аймгийн Зэрэг сумын "Сумын төвийн усан хангамжийг нэмэгдүүлэх инженерийн шугам сүлжээний өргөтгөл"-д нэмэлт ажлын гэрээ хийж, санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Батбилэг - Зэрэг сумын Засаг дарга

Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

М.Баярт - Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Л.Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ш.Батсуурь - "Тулгат багана" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. "Сумын төвийн усан хангамжийг нэмэгдүүлэх инженерийн шугам сүлжээний өргөтгөл"-ийн нэмэлт ажлыг гүйцэтгэх эсэх талаар зураг төсвийн дагуу шалгаж, хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02 2278
Zah A/667 Kh